



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРОО



2017

БАРИЛГЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА

Барилгын салбарын статистикийн танилцуулгатай холбоотой мэдээлэл, санал, хүсэлтээ доорх хаягаар илгээнэ үү.

Үндэсний статистикийн хороо

Хаяг: Засгийн газрын III байр,
Бага тойруу - 44, Улаанбаатар -11
Монгол улс

Вэб хаяг: www.nso.mn, www.1212.mn

Олон нийттэй харилцах хэлтэс

Онлайн: <http://web.nso.mn/onlinechat/index.php>

Утас: 1900-1212

Танилцуулгыг бэлтгэсэн:

ЭЗСГ-ын статистикч Д.Баасан

И-мэйл: baasan@nso.mn

Утас: 51-261563

Танилцуулгыг хянасан:

ЭЗСГ-ын дарга Э.Эрдэнэсан

ЭЗСГ-ын ахлах статистикч М.Оюунжаргал

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	4
Өмнөх үг.....	5
I. Барилгын салбарын хамрах хүрээ, ойлголт, тодорхойлолт.....	8
II. Монгол Улсад барилгын салбарын эзлэх байр суурь.....	12
III. Ашиглалтад оруулсан барилга угсралт, их засварын ажил.....	26
IV. Барилгын зарим нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт.....	34
V. Барилгын салбарын ажиллагчдын тоо, дундаж цалин.....	38
VI. Орон сууцны үнэ, ипотекийн зээл.....	42
VII. Барилгын салбарын дэлхийн хөгжлийн чиг хандлага.....	54
Дүгнэлт.....	58

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БР	Статистикийн бизнес регистрийн сан
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХТ	Барилгын хөгжлийн төв
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НӨ	Нэмэгдэл өртөг
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
СЯ	Сангийн яам
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ТЕГ	Татварын ерөнхий газар
ЭЗБТУАСА	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

ТЭМДЭГЛЭГЭЭ

*	Урьдчилсан гүйцэтгэл
м ²	Метр квадрат
м ³	Метр куб

Ардын хувьсгал ялж, 1924 онд анхны үндсэн хуулиа батлан Бүгд Найрамдах Монгол Ард Улс хэмээн Улсын нийслэлийг Улаанбаатар гэж нэрлэсэн билээ. Үүнтэй уялдуулан эдэлбэр газрыг 104 га байхаар тогтоон Хиагт, Ховд, Улиастай зэрэг сууринг Монгол Улсын хот болгон бусад 115 хүрээ сууринд аймаг, сумын засаг захиргаа, соёлын асуудлыг төвлөрүүлэх тогтоол гаргасан нь дэлхийн соёл иргэншлийн нэг хэлбэр болох суурьшмал хот, суурин байгуулах үзэл баримтлалын анхны үр хөврөл, хууль эрх зүйн баримт бичиг болж түүхэнд үлдсэн билээ.

Барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд 1920-иод оны дунд үеэс хөрөнгө оруулалт, барилга угсралтын ажлын бүртгэлийг өөрийн онцлог байдлыг харгалзан бий болгож, хөтөлж эхэлсэн байна. Барилга, байгууламж тоног төхөөрөмжийн тооллогыг 1926, 1927, 1930 онд хүн ам, малын тооллоготой хамт явуулж байжээ. 1926 онд явуулсан хошуу, жасын үл хөдлөх хөрөнгийн тооллогоор 30 гаруй мянган орон байшин тоологдсон байна. Монголын хувь нийлүүлсэн барилгын хоршоо, хувь нийлүүлсэн “Монгол транс” нийгэмлэгийн харьяанд 1926 онд зам, барилгын ажлыг гүйцэтгэх ерөнхий газар, мал аж ахуйн яамны дэргэд 1929 онд худаг усны хайгуул, барилгын ажлыг эрхэлсэн усан хангамжийн салбар, аж үйлдвэр, барилгын яамны харьяанд 1938 онд барилгын үйлдвэрлэлийг эрхлэн гүйцэтгэх трест, мөн аж ахуйн аргаар барилгын ажил гүйцэтгэгч, захиалагчийн газар 1937 онд байгуулагдсанаар эдгээр салбарт барилгын статистикийн нэгж бий болсон байна. Барилгын салбарын статистик мэдээллийг 1940-өөд оны сүүлчээс 1959 он хүртэл хөрөнгө оруулалт, барилга угсралт гэсэн төрлөөр тухайн үеийн мөнгөн тэмдэгтээр, үнийн дүнгээр тооцож, төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн, хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажлыг захиалагч, гүйцэтгэгч байгууллагаар бүлэглэн гаргаж байжээ. Ялангуяа объект бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, барилгын ажлын түвшинг сар, улирал, жилээр тодорхойлж, төлөвлөгөөний биелэлтийг тогтмол хугацаагаар дүгнэдэг байх үүргийг гүйцэтгэж байжээ. 1960-аад оноос эхлэн барилгын бүртгэлийн ажилд ахиц гарч, барилгын захиалагч, гүйцэтгэгч, зураг төсвийн байгууллагын төлөвлөгөөт зорилтын биелэлтэд тогтмол хяналт тавих, программын үндсэн дээр зохион байгуулалттай статистик ажиглалтыг явуулах бололцоо, нөхцөл бүрджээ. Барилгын мэдээ, тайлангийн маягт, зааврыг 1960 онд Тоо бүртгэлийн улсын төв газраас шинэчлэн боловсруулж, мөрдүүлж эхлэв.

БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1961 оны 636 дугаар тогтоолоор барилгын байгууллагын улсын чанартай тайлан мэдээг яам, тусгай газрууд өөрийн системээр нэгтгэж, Тоо бүртгэлийн улсын төв газарт ирүүлж байсан журмыг өөрчлөн, аймаг, хотын статистикийн товчоодоор дамжуулан Тоо бүртгэлийн улсын төв газарт мэдээлж байх журам тогтоосноор нэгдсэн системд орсон. Хөрөнгө оруулалт, ашиглалтад оруулах хүчин чадлын үзүүлэлтийг 1970-аад оноос захиалагч яам, аймаг, хот, улс ардын аж ахуйн болон аж үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд салбараар бүлэглэн дүгнэж, судалгаа шинжилгээг хийж төрийн бодлогод статистикийн тоо, мэдээг өргөнөөр хэрэглэх болсон байна.

Төр, засгаас 1988 оноос их барилга, хөрөнгө оруулалтын салбарт ихээхэн анхаарал хандуулж, төвлөрсөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах үүднээс олон тооны нарийвчилсан, дэлгэрэнгүй үзүүлэлтээр мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийдэг байсан. Хөрөнгө оруулалт, ашиглалтад оруулсан үндсэн фондын төлөвлөгөөний биелэлтийн жилийн тайлангаар хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг технологийн бүтцээр, улс ардын аж ахуйн салбараар ангилан гаргаж байв.

ҮСХ нь барилгын салбарын албан ёсны статистикийн мэдээ, тайланг аж ахуйн нэгж, байгууллагаас аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсээр дамжуулан цуглуулж, БХБЯ, БХТ, ЗТХЯ, МХЕГ зэрэг төрийн байгууллагуудын захиргааны статистик мэдээлэлтэй уялдуулан шалгаж, барилгын салбарт гарч байгаа өөрчлөлтийг тухай бүрт тусгасан маягт, зааврын дагуу мэдээллийг цуглуулж ирсэн.

Барилгын салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг бодитоор тооцох, үнэ, өртгийн өөрчлөлтийн нөлөөллийг тодорхойлох үүднээс 2007 онд “Барилгын өртгийн индекс тооцох аргачлал”-ыг баталж, барилгын салбарын тооцоо, судалгаанд ашиглаж эхэлсэн. Барилгын өртгийн индексийн эхний шатны судалгаа буюу барилгын ажилд зарцуулагдаж байгаа бүтээгдэхүүний орц, түүний жинг тооцож гаргах, жинд үндэслэн барилгын өртгийн индексийн тооцоонд ашиглагдах түүхий эд, бүтээгдэхүүнийг тодорхойлох судалгааг 2010 онд явуулж, суурь үнийг 2010 оноор шинэчилснээр барилгын салбарын бүтээгдэхүүнийг зэрэгцүүлэх үнээр тооцох боломж бүрдсэн.

Мөн барилгын салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр буюу ДНБ-д эзлэх хувь, нэмэгдэл өртгийн тооцоог албан болон албан бус сектороор тооцон гаргаж байна.

Салбарын албан секторт ҮСХ-ны бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг, харин албан бус секторт хувиараа барилга угсралт, их засварын үйл ажиллагаа эрхэлдэг иргэдийн үйл ажиллагааг хамруулж байна. Энэ удаагийн танилцуулгад сүүлийн 10 жилийн барилгын салбарын статистик мэдээлэл буюу 2007-2017 оныг хамруулан бэлтгэлээ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ХАМРАХ ХҮРЭЭ, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Ойлголт	Тодорхойлолт
Объект	Бие даасан барилга (орон сууц, үйлдвэрийн гол корпус, сургууль, цех, агуулах) буюу байгууламж (зам, гүүр, далан, суваг, нүхэн гарц) түүнтэй холбогдож хийгдэх үндсэн ба туслах чанарын бусад байгууламж, гадна инженерийн бүх төрлийн шугам сүлжээ, хийц тоноглол, барилгын талбайд хийгдэх өндөржилт, тохижилтын бүх ажил
Барилга байгууламж	Олон төрлийн зориулалтаар шинээр буюу өргөтгөл, шинэчлэл хийх, нэгдсэн зураг төслөөр баригдах байгууламж
Барилга угсралт, их засварын ажил	Барилга, байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагаа
Орон сууцны барилга	Хамгийн багадаа түүний тал хэсгийг нь орон сууцны зориулалтаар ашигладаг байгууламж
Орон сууцны бус барилга	Барилгын багахан хэсгийг (Нийт талбайн 50 хувиас бага хэсэг) орон сууцны зориулалтаар ашигладаг барилгыг оруулна.
Инженерийн барилга, байгууламж	Төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, усан хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга, байгууламжийн бүх ажил

Хамрах хүрээ

Барилгын салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 4.0)-ын дагуу барилга угсралт, иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаа, барилгын тусгай үйл ажиллагаа гэсэн 3 дэд салбарын ажиллагааг хамруулан авч үздэг.

F				БАРИЛГА
41	410	4100	Барилга угсралт	
42				Иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаа
	421	4210	Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа	
	422	4220	Нийтийн аж ахуйн барилга угсралт	
	429	4290	Иргэний инженерийн бусад байгууламж үйлдвэрлэл	
43				Барилгын тусгай үйл ажиллагаа
	431			Буулгах/нураах ба барилгын талбай бэлтгэх үйл ажиллагаа
		4311	Барилгыг буулгах/нураах үйл ажиллагаа	
		4312	Барилгын талбай бэлтгэх үйл ажиллагаа	

432		Цахилгааны, гүний ус дамжуулах хоолойн болон барилгын бусад суурилуулах үйл ажиллагаа
	4321	Цахилгааны байгууламж суурилуулах үйл ажиллагаа
	4322	Ус, дулааны шугам сүлжээ, агааржуулагч суурилуулах үйл ажиллагаа
	4329	Барилгын бусад суурилуулах үйл ажиллагаа
433	4330	Барилгыг дуусгах шатны ажил
439	4390	Барилгын бусад тусгай үйл ажиллагаа

Барилга угсралтын үйл ажиллагаа (41) нь дотроо 1 ангитай. Үүнд:

- Барилга угсралт (4100)

Энэ ангид өөрийн хөрөнгөөр, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр гүйцэтгэж ашиглалтад орсон орон сууцны болон орон сууцны бус барилга, байгууламжуудыг барих үйл ажиллагаа багтана. Тухайн барилгын зарим хэсгийг өөр гүйцэтгэгч байгууллага эсвэл бүхлээр нь тухайн гүйцэтгэгч байгууллага гүйцэтгэж болно. Хэрэв зөвхөн барилгын үйл ажиллагааны тусгай хэсгийн үйл ажиллагаа байвал үйл ажиллагаа нь дэд салбар 43-т ангилагдана.

Энэ ангид дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

- Орон сууцны бүх төрлийн барилга байгууламж барих үйл ажиллагаа, нэг өрхийн байшин, олон давхар байшин, олон өрхийн орон сууц

- Орон сууцны бус барилга, байгууламжийг барих үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх зориулалттай барилга байгууламж, үйлдвэрийн зориулалттай, сургалт семинар, хурал цуглаан хийх зориулалт бүхий танхим, өрөө, эмнэлэг, сургууль, конторын барилга, зочид буудал, дэлгүүр, худалдааны төв, зах, ресторан, онгоцны буудал; спортын байгууламж, газар доорх машин тавих зогсоолыг оруулан машины зогсоол; барааны агуулах; шашны зориулалттай барилга, байгууламж, сүм хийд

- Үйлдвэрлэлийн барилгыг барих, угсрах үйл ажиллагаа

Түүнчлэн орон сууцны зориулалт бүхий барилга, байгууламжийг шинэчлэх, сэргээх үйл ажиллагаа хамаарна.

Иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаа (42) нь 3 бүлэг, 3 ангитай. Үүнд:

- Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа (4210)
- Нийтийн аж ахуйн барилга угсралт (4220)
- Иргэний инженерийн бусад байгууламж үйлдвэрлэл (4290)

Барилгын тусгай үйл ажиллагаа (43) нь 3 бүлэг, 7 ангитай. Үүнд:

- Барилгыг буулгах / нураах үйл ажиллагаа (4311)
- Барилгын талбай бэлтгэх үйл ажиллагаа (4312)
- Цахилгааны байгууламж суурилуулах үйл ажиллагаа (4321)
- Ус, дулааны шугам сүлжээ, агааржуулагч суурилуулах үйл ажиллагаа (4322)
- Барилгын бусад суурилуулах үйл ажллагаа (4329)
- Барилгыг дуусгах шатны ажил (4330)
- Барилгын бусад тусгай үйл ажиллагаа (4390)


Мэдээлэл цуглуулах маягт, түүнийг нөхөх заавар

Барилгын салбарт дараах 3 төрлийн мэдээний маягтаар ААНБ-уудаас мэдээллийг цуглууж байна.

Маягтын нэр			Тушаал
Барилга, байгууламж улирлын мэдээ	объектын	ББО-1	ҮСХ-ны даргын 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/117 тоот тушаал
ААНБ-ын 20.. оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ		ААНБ-1	ҮСХ-ны даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 1/161 тоот тушаал
ААНБ-ын 20.. оны үйл ажиллагааны хураангуй мэдээ		ААНБ-2	

ХОЁРДУГААР БҮЛЭГ
МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ БАРИЛГЫН
САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ



БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр



БАРИЛГЫН САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО




2. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ БАРИЛГЫН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2.1. Аж ахуйн нэгж, байгууллага

ҮСХ-ны бизнес регистрийн санд 2017 оны эцэст нийт 155.1 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 12.1 мянга буюу 7.8 хувь нь барилгын салбарт хамаарч байна.


Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын дүнд барилгын салбарт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь өмнөх оноос 0.3 пунктээр буурсан бол, 2007 оноос 4.3 пункт, 2012 оноос 2.1 пунктээр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН НИЙТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ, жил бүрийн эцэст



Барилгын салбарт бүртгэлтэй 12.1 мянган ААНБ-аас 6.3 мянга буюу 52.4 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 0.3 мянган ААНБ буюу 4.5 хувиар, 2007 онтой харьцуулахад 5.1 мянган ААНБ буюу 5.1 дахин, 2012 онтой харьцуулахад 3.2 мянган ААНБ буюу 2.0 дахин нэмэгдсэн байна.

ЗУРАГ 2. БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, жил бүрийн эцэст



Барилгын салбарт бүртгэлтэй ААНБ-ын тоо 2017 оны эцэст 12 103 болж өмнөх онтой харьцуулахад 673 ААНБ буюу 5.9 хувь, 2007 оноос 9 995 ААНБ буюу 5.7 дахин, 2012 оноос 6 673 ААНБ буюу 2.2 дахин нэмэгдсэн байна.


Тус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо тасралтгүй өссөн нь төрөөс ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй зээл, барилгын материалын үнэ, орон сууцны үнэ тогтворжуулах хөтөлбөр гэх мэт хүн амыг орон сууцаар хангах бодлогыг хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

ХҮСНЭГТ 1. БАРИЛГЫН САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО, жил бүрийн эцэст

Он	Бүртгэлтэй ААНБ	Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ	Эзлэх хувь
2007	2 108	1 233	58.5
2008	2 372	1 313	55.4
2009	2 611	1 064	40.8
2010	3 057	1 452	47.5
2011	4 226	2 831	67.0
2012	5 430	3 135	57.7
2013	6 529	3 541	54.2
2014	8 940	4 770	53.4
2015	10 496	5 390	51.4
2016	11 430	6 074	53.1
2017	12 103	6 345	52.4


Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 6.3 мянган ААНБ-ын 5.3 мянга буюу 84.0 хувь нь Улаанбаатар хотод, 1.0 мянга буюу 16.0 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

ЗУРАГ 3. БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН БҮТЭЦ, бүсээр



Барилгын салбарын ААНБ-ууд хүн амын төвлөрөл ихтэй хот, суурин газруудад илүү олноор үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, Улаанбаатар хотод 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт ААНБ-ын 84 хувь нь үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оноос 0.1 пунктээр, 2007 оноос 6.2 пунктээр, 2012 оноос 1.8 пунктээр тус тус өссөн байна.

ЗУРАГ 4. БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ТОО, аймаг, нийслэлээр, 2017 он



Дээрх зургаас харахад хүн ам олноор төвлөрсөн хот, суурин газрууд болох Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймгуудын ААНБ-ын тоо бусад аймгуудаас илүү байна. Харин Өвөрхангай, Сүхбаатар, Говьсүмбэр аймгуудын ААНБ-ын тоо бусад аймгуудаас бага байна.

2.2. Барилгын салбар нэмэгдэл өртөг

Монгол Улсын ДНБ-ий хэмжээ 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 27.9 их наяд төгрөгт хүрсний 1.0 их наяд төгрөг буюу 3.7 хувийг барилгын салбар бүрдүүлж байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн хэмжээ 1.0 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 73.8 тэрбум төгрөг буюу 7.8 хувиар, 2007 оноос 916.5 тэрбум төгрөг буюу 9.7 дахин, 2012 оноос 185.4 тэрбум төгрөг буюу 22.1 хувиар тус тус нэмэгдсэн байна. Барилгын салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь 2017 онд 3.7 хувь байгаа нь өмнөх оноос 0.3 пунктээр, 2012 оноос 1.3 пунктээр тус тус буурсан бол 2007 оноос 1.6 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 2. БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, тэрбум төгрөгөөр


Он	ДНБ, оны үнээр, тэрбум төгрөг	Барилгын салбарын нэмэгдэл өртөг, оны үнээр, тэрбум төгрөг	Барилгын салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь	Барилгын салбарын нэмэгдэл өртгийн өсөлтийн хувь
2007	4 956.6	106.4	2.1	-
2008	6 555.6	122.1	1.9	114.7
2009	6 590.6	86.2	1.3	70.7
2010	9 756.6	250.2	2.6	2.9 ¹
2011	13 173.8	402.8	3.1	161.0
2012	16 688.4	837.5	5.0	2.1 ¹
2013	19 174.2	979.7	5.1	117.0
2014	22 227.1	989.0	4.4	100.9
2015	23 150.4	978.0	4.2	98.9
2016	23 942.9	949.1	4.0	97.0
2017*	27 895.5	1 022.9	3.7	107.8

* - урьдчилсан гүйцэтгэл

¹ – дахин их

Барилгын салбарын нэмэгдэл өртгийг сүүлийн 10 жилээр авч үзвэл, хамгийн оргил үе нь 2017 онд 1 022.9 тэрбум төгрөгт хүрсэн нь хамгийн их, 2009 онд 86.2 тэрбум төгрөгт хүрсэн нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

ЗУРАГ 5. ДНБ, БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, тэрбум төгрөгөөр




* урьдчилсан гүйцэтгэл

2.3. Барилга угсралт, их засварын ажил

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2017 онд 3 674.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 392.1 тэрбум төгрөг буюу 11.9 хувиар, 2007 оноос 3 285.5 тэрбум төгрөг буюу 9.4 дахин, 2012 оноос 2 640.7 тэрбум төгрөг буюу 3.6 дахин нэмэгдсэн байна. Барилга угсралт, их засварын ажлын 87.3 хувийг дотоодын, 12.7 хувийг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна. Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн ажлын 95.5 хувийг хувийн байгууллага, 2.8 хувийг гадаадтай хамтарсан байгууллага, 1.7 хувийг төрийн өмчийн байгууллага гүйцэтгэсэн байна.

ЗУРАГ 6. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, аймаг, нийслэлээр, тэрбум төгрөгөөр




ХҮСНЭГТ 3. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, дотоод, гадаадын байгууллагаар, тэрбум төгрөгөөр, жил бүрийн эцэст


Он	Барилга угсралт, их засварын ажил	Үүнээс:		
		Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн	Гадаадтай хамтарсан байгууллагын гүйцэтгэсэн	Гадаадын байгууллагын гүйцэтгэсэн
2007	389.4	364.4	34.2	25.0
2008	508.2	479.6	33.7	28.6
2009	418.0	373.6	26.0	44.4
2010	463.0	442.7	27.0	20.3
2011	745.0	657.2	15.4	87.8
2012	1 034.1	919.7	56.6	114.4
2013	1 845.9	1719.5	24.9	126.4
2014	2 702.9	2 511.6	48.7	191.3
2015	3 200.4	2 991.5	21.3	208.9
2016	3 282.7	3 016.8	17.2	265.9
2017	3 674.8	3 206.8	87.8	468.0

2017 онд барилга угсралт, их засварын ажлын 5.9 хувийг нэгдүгээр улиралд, 34.4 хувийг хоёрдугаар улиралд 38.8 хувийг гуравдугаар улиралд, 20.9 хувийг дөрөвдүгээр улиралд тус тус гүйцэтгэсэн байна.


ЗУРАГ 7. 2017 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, улирлаар



ЗУРАГ 8. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, аймаг, нийслэлээр, сая.төг



ЗУРАГ 9. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН БҮТЭЦ, өмчийн хэлбэрээр, 2017



ХҮСНЭГТ 4. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, өмчийн хэлбэрээр

Он	Нийт	Үүнээс:		
		Хувийн байгууллагын гүйцэтгэсэн ажлын хувь	Төрийн өмчийн байгууллагын гүйцэтгэсэн ажлын хувь	Гадаадтай хамтарсан байгууллагын гүйцэтгэсэн ажлын хувь
2007	100.0	78.8	11.9	9.4
2008	100.0	85.4	7.6	7.0
2009	100.0	87.7	5.3	7.0
2010	100.0	85.3	8.6	6.1
2011	100.0	91.0	6.7	2.3
2012	100.0	90.3	3.5	6.2
2013	100.0	91.1	7.5	1.4
2014	100.0	95.5	2.5	2.0
2015	100.0	97.7	1.5	0.8
2016	100.0	98.4	1.0	0.6
2017	100.0	95.5	1.7	2.8


Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, хувийн байгууллагын гүйцэтгэсэн ажил 2017 онд хамгийн өндөр буюу 95.5 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 2.9 пунктээр буурсан бол 2007 оноос 16.7 пунктээр, 2012 оноос 5.2 пунктээр тус тус өссөн байна. Цаашид хувийн барилгын байгууллагын гүйцэтгэсэн ажлын эзлэх хувь нийт барилга угсралт, их засварын ажлын дүнд дийлэнх хувийг эзлэх хандлага хэвээр хадгалагдахаар харагдаж байна.

ЗУРАГ 10. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр, 2017




Барилга угсралт, их засварын ажлын хэмжээг төрлөөр авч үзвэл, орон сууцны барилгын нийт дүнд эзлэх хувь өмнөх оноос 0.6 пунктээр буурсан бол 2007 оноос 8.2 пунктээр, 2012 оноос 2.5 пунктээр тус тус өссөн байна.

ЗУРАГ 11. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр, хувиар, жил бүрийн эцэст



2017 онд инженерийн байгууламж болон их засварын ажлын нийт дүнд эзлэх хувь өмнөх оноос 0.8-3.6 пунктээр нэмэгдсэн байна. Харин орон сууцны болон орон сууцны бус барилгын нийт дүнд эзлэх хувь 0.6-3.9 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 12. БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр, хувиар



Барилга угсралтын ажлыг барилгын төрлөөр авч үзвэл, орон сууцны бус барилга 2017 онд хамгийн их буюу 37.5 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 3.4 пунктээр буурсан бол 2007 оноос 22.1 пунктээр, 2012 оноос 2.7 пунктээр тус тус нэмэгдсэн байна. Орон сууцны барилга нийт барилга угсралт, их засварын ажлын 34.5 хувийг эзэлж байгаа

бөгөөд өмнөх онтой харьцуулахад 1.1 пунктээр буурсан бол 2007 оноос 7.7 пунктээр, 2012 оноос 2.0 пунктээр тус тус өссөн байна. Инженерийн байгууламж нийт дүнд 25.7 хувийг эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3.6 пунктээр, 2012 оноос 6.1 пунктээр тус тус өссөн бол 2007 оноос 16.2 пунктээр буурсан байна. Харин их засварын ажлын хэмжээ хамгийн бага буюу 2.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 0.8 пунктээр өссөн бол 2007 оноос 13.6 пунктээр, 2012 оноос 10.8 пунктээр тус тус буурсан байна. 2007 онд инженерийн байгууламжийн болон их засварын ажлын хэмжээ 57.8 хувийг эзэлж байсан бол 2017 онд 28.4 хувь болж буурсан нь сүүлийн 10 жилийн хугацаанд орон сууцны болон орон сууцны бус барилга ихээр баригдаж, салбарын бүтцэд томоохон өөрчлөлт, шинэчлэлт гарсныг харуулж байна.

ХҮСНЭГТ 5. БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН БҮЛЭГЛЭЛТ, гүйцэтгэсэн барилга, угсралт, их засварын ажлын хэмжээгээр, жил бүрийн эцэст

Он	Бүгд	10 сая төгрөг хүртэл	11-50	51-100	101-500	500 сая төгрөгөөс дээш
2007	100.0	0.3	1.7	3.0	18.6	76.5
2008	100.0	0.1	0.7	1.4	12.6	85.2
2009	100.0	0.1	0.9	1.4	17.1	80.5
2010	100.0	0.1	1.0	1.9	22.8	74.4
2011	100.0	0.1	0.8	0.9	9.4	88.8
2012	100.0	0.0	0.4	0.8	10.4	88.4
2013	100.0	0.0	0.2	0.5	4.5	94.9
2014	100.0	0.0	0.2	0.4	3.5	95.9
2015	100.0	0.0	0.1	0.3	2.2	97.4
2016	100.0	0.0	0.1	0.2	2.0	97.7
2017	100.0	0.0	0.2	0.4	2.0	97.4

Барилга угсралт, их засварын ажлын хэмжээг гүйцэтгэлээр нь бүлэглэн авч үзвэл, 97.4 хувийг 500 сая буюу түүнээс дээш гүйцэтгэлтэй ААНБ, 2.0 хувийг 101-500 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ААНБ, 0.4 хувийг 51-100 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ААНБ, 0.2 хувийг 11-50 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ААНБ тус тус бүрдүүлж байна. 2007 онд 11-50 хүртэлх сая төгрөгийн гүйцэтгэлтэй ААНБ-ууд 1.7 хувийг эзэлж байсан бол 2017 онд 1.5 пунктээр, 51-100 хүртэлх сая төгрөгийн гүйцэтгэлтэй ААНБ-ууд 3 хувийг эзэлж байсан бол 2017 онд 2.6 пунктээр, 101-500 хүртэлх сая төгрөгийн гүйцэтгэлтэй ААНБ-ууд 18.6 хувийг эзэлж байсан бол 2017 онд 16.6 пунктээр тус тус буурсан бол 500 сая буюу түүнээс дээш төгрөгийн гүйцэтгэлтэй ААНБ-ууд 76.5 хувийг эзэлж байсан бол 2017 онд 97.4 хувь буюу 20.9 пунктээр нэмэгдсэн байна.

Сүүлийн 10 жилийн хандлагаас харахад 101-500 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ААНБ-уудын эзлэх хувь 500 саяас дээш гүйцэтгэлтэй ААНБ-ын бүлэг рүү нэмэгдэж байна. Энэ нь үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-уудын үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж, салбарын бүтцэд маш том өөрчлөлт шинэчлэлт гарч байгааг харуулж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ
АШИГЛАЛТАД ОРУУЛСАН БАРИЛГА УГСРАЛТ,
ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

2016

2017

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СҮРГҮҮЛЬ, СОЁЛЫН БАРИЛГА,
мянган суудал

18.3



19.1

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ЭМНЭЛЭГ, орны тоогоор

1 358



534

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН АВТО ЗАМ, км

405



376.6

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СҮҮЦ, мянган айл

19.1



18.7

3. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

3.1. Ашиглалтад оруулсан орон сууцны барилга


ХҮСНЭГТ 6. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА, тэрбум төгрөгөөр, мянган айлаар, жил бүрийн эцэст

Он	Ашиглалтад оруулсан орон сууц, тэрбум төгрөг	Ашиглалтад орсон айлын тоо, мянган айл
2007	71.6	3.7
2008	270.3	5.4
2009	208.9	6.3
2010	344.5	9.9
2011	387.8	11.3
2012	389.4	11.4
2013	856.9	18.0
2014	2 533.9	23.8
2015	2 666.8	23.8
2016	2 200.1	19.1
2017	2 106.0	18.7

2007 онд 3.7 мянган айлын орон сууц ашиглалтад оруулсан нь сүүлийн 10 жилийн хугацаанд хамгийн бага хэмжээнд байж, харин 2014 онд 23.8 мянган айлын орон сууц ашиглалтад оруулсан нь хамгийн их орон сууц ашиглалтад оруулсан жил байлаа.

3.2. Ашиглалтад оруулсан орон сууцны 1 м² талбайн дундаж өртөг

ЗУРАГ 13. АШИГЛАЛТАД ОРСОН ОРОН СУУЦНЫ 1 м² ТАЛБАЙН ДУНДАЖ ӨРТӨГ, сая төгрөгөөр, аймаг, нийслэлээр, 2017 он



2017 онд ашиглалтад оруулсан орон сууцны 1 м.кв талбайн дундаж өртгийг аймаг, нийслэлээр авч үзвэл, хөдөө орон нутагт ашиглалтад орсон орон сууцны 1 м.кв талбайн өртөг улсын дунджаас доогуур байна. Улаанбаатар хотод ашиглалтад орсон орон сууцны өртөг улсын дунджаас 498.7 мянган төгрөгөөр дээгүүр байгаа бөгөөд орон нутагт ашиглалтад орсон орон сууцны 1 м.кв талбайн дундаж өртгөөс харьцангуй өндөр түвшинд байна.

3.3. Ашиглалтад оруулсан орон сууцны 1 айлд ногдох өртөг


ЗУРАГ 14. АШИГЛАЛТАД ОРСОН ОРОН СУУЦНЫ 1 АЙЛД НОГДОХ ӨРТӨГ, сая төгрөгөөр, аймаг, нийслэлээр



Ашиглалтад орсон орон сууцны 1 айлд ногдох өртгийн хэмжээ улсын дунджаар 83.0 сая төгрөг байгаа бөгөөд орон нутагт ашиглалтад орсон орон сууцны 1 айлд ногдох өртөг улсын дунджаас доогуур түвшинд байна.


Орон сууцны нэг айлд ногдох өртгийн хэмжээ Улаанбаатар хотод дунджаар 96.4 сая төгрөг байгаа нь улсын дунджаас 13.4 сая төгрөгөөр илүү байна. Энэ нь байршлын онцлогоос хамааран газрын үнэ, бараа материалын үнэ, хөдөлмөрийн нөөцийн зардал өндөр, мөн түүнчлэн үйлчилгээний зориулалтын талбай ихтэй орон сууц их баригдаж байгаатай холбоотой байна.

ЗУРАГ 15. АШИГЛАЛТАД ОРСОН ОРОН СУУЦ, айлын тоогоор, аймгаар, 2017 он




Улсын хэмжээнд 2017 онд 18 685 айлын орон сууц ашиглалтад орсон нь 16 907 буюу 90.5% нь Улаанбаатар хотод, 1 778 буюу 9.5% нь орон нутагт ашиглалтад орсон байна. Аймгаар авч үзвэл, Дорноговь аймагт хамгийн их буюу 472 айлын орон сууц ашиглалтад орсон нь нийт дүнгийн 2.5%, Дархан-Уул аймагт 276 орон сууц ашиглалтад орсон нь 1.5%, Төв аймагт 197 айлын орон сууц ашиглалтад орсон нь 1.1%-ийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 16. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, аймаг, нийслэлээр, хувиар, 2017 он




ЗУРАГ 17. АШИГЛАЛТАД ОРСОН ОРОН СУУЦНЫ 1 АЙЛД НОГДОХ ТАЛБАЙН ДУНДАЖ ХЭМЖЭЭ, метр квадратаар, аймаг, нийслэлээр



2017 онд улсын хэмжээнд ашиглалтад орсон орон сууцны 1 айлд ногдох талбайн дундаж хэмжээ 65.3 м² байна.

Ашиглалтад орсон орон сууцны 1 айлд ногдох талбайн дундаж хэмжээ Өмнөговь аймагт хамгийн өндөр буюу 73.9 м², Увс аймагт 73.7 м² байгаа нь улсын дунджаас 8.4-8.6 м²-аар өндөр байна.


ЗУРАГ 18. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, СОЁЛЫН БАРИЛГА, мянган суудлаар, жил бүрийн эцэст



2017 онд нийт 19.1 мянган суудал бүхий сургууль, соёлын барилгыг ашиглалтад оруулсан байна. Энэ нь өмнөх оноос 0.8 мянга буюу 4.4 хувиар, 2007 оноос 7.5 мянга буюу 64.7 хувиар тус тус өсөж, 2012 оноос 0.5 мянга буюу 2.6 хувиар буурсан байна.


2008 онд 7.9 мянган суудал бүхий сургууль, соёлын барилга ашиглалтад оруулсан нь хамгийн бага үзүүлэлт байгаа бол 2014, 2015 онуудад 23.8 мянган суудал бүхий сургууль, соёлын барилга ашиглалтад оруулсан нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

ЗУРАГ 19. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ЭМНЭЛЭГ, орны тоогоор, жил бүрийн эцэст



2017 онд 534 ор бүхий эмнэлгийн барилга ашиглалтад орсон байна. Энэ нь өмнөх оноос 824 ор буюу 60.7 хувиар буурсан бол 2007 оноос 214 ор буюу 66.9 хувиар өсөж, 5 жилийн өмнөхөөс буюу 2012 оноос 79 ор буюу 12.9 хувиар буурсан байна.

ЗУРАГ 20. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН АВТО ЗАМ, км, жил бүрийн эцэст



2017 онд улсын хэмжээнд 376.6 км авто замыг шинээр ашиглалтад оруулсан нь өмнөх оноос 28.4 км буюу 7 хувиар буурсан бол 2007 оноос 96.6 км буюу 34.5 хувиар, 2012 оноос 256.6 км буюу 3.1 дахин тус тус нэмэгдсэн байна.

Зам тээврийн хөгжлийн яамны тайлангаар Монгол Улс нь нийт 49 250 км авто замын сүлжээтэйгээс 12 646.7 км нь нийслэлийг аймгийн төвтэй, аймгийн төвийг хооронд нь болон хилийн боомттой холбосон улсын чанартай авто зам, 36 603.3 км орон

нутгийн чанартай авто зам юм. Улсын чанартай авто замын 5 690 км нь Улаанбаатар хотыг аймгийн төвүүдтэй холбосон авто зам байна.

ХҮСНЭГТ 7. АЙМГИЙН ТӨВҮҮДЭЭС УЛААНБААТАР ХОТ ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН УРТ, КМ

Авто замын өнөөгийн байдал	Нийт урт, км	Үүнээс		
		Хатуу хучилттай, км	Баригдаж байгаа, км	Үлдэгдэл, км
Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой холбосон авто зам	5 690.0	4 786.5	542.8	360.7

Эх үүсвэр: ЗТХЯ-ны тайлан

2017 оны байдлаар Төв, Дархан-Уул, Орхон, Булган, Сэлэнгэ, Архангай, Өвөрхангай, Говьсүмбэр, Хэнтий, Дундговь, Дорноговь, Баянхонгор, Сүхбаатар, Хөвсгөл, Өмнөговь, Дорнод гэсэн 16 аймгийн төв нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдоод байна. Үүнээс Хөвсгөл, Дундговь, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Баянхонгор, Дорнод аймгуудыг 2012-2017 онд шинээр холбосон ба нийт 3 891.2 км хатуу хучилттай авто зам барьж ашиглалтад оруулсан нь улсын чанартай авто замын сүлжээний 48.1 хувь буюу нийт 6 234.9 км нь хатуу хучилттай болоод байна. Мөн аймгийн төвүүдийг нийслэл хоттой холбох ажлын хүрээнд 43 сум, бусад чиглэлээр 6 сум холбогдоод байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бүх аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах зорилтын хүрээнд 2017 онд Дорнод аймгийн төвийг нийслэл хоттой холбож Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хийж дуусгасан бөгөөд 2018-2020 онд Завхан, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбохоор зорилт тавин ажиллаж байна.

Үлдэж буй баруун 5 аймаг буюу Завхан, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн төвүүдийг нийслэл хоттой холбох ажлын хүрээнд тус яамны зүгээс Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр баруун босоо тэнхлэгийн Ховд-Баян-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км авто зам, БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км, Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэж байна.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ**

БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ 2017



ЦЕМЕНТ, мянган тонн	675.2
БЕТОН ЗУУРМАГ, мянган метр куб	102.5
ШОХОЙ, мянган тонн	56.2

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧИД, СУРАЛЦАГЧДЫН ТОО



НИЙТ АЖИЛЛАГЧИД, мянган хүн	70.8
НИЙТ СУРАЛЦАГЧИД, мянган хүн	24.3
ШИНЭЭР ЭЛСЭГЧИД, мянган хүн	9.0
ТӨГСӨХ АНГИЙН СУРАЛЦАГЧИД, мянган хүн	9.6

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН



ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөг	852.3
ЭМЭГТЭЙ АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөг	822.2


БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ИМПОРТ



ЦЕМЕНТ, мянган тонн	91.0
ЦОНХНЫ ШИЛ, мянган м2	1 443.2
ШИЛЭН РАДИАТОР, тонн	312.6

4. БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ

ЗУРАГ 21. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, жил бүрийн эцэст



Барилгын материалын гол бүтээгдэхүүн болох цементийн үйлдвэрлэл 2017 онд 675.2 мянган тонн болж, өмнөх оноос 242.8 мянган тонн буюу 56.2 хувиар, 2012 оноос 325.9 мянган тонн буюу 93.3 хувиар, 2007 оноос 495.4 мянган тонн буюу 3.8 дахин нэмэгджээ. Харин шохой үйлдвэрлэл 2017 онд 56.2 мянган тонн болж, өмнөх оноос 8.6 мянган тонн буюу 18.0 хувиар, 2007 оноос 12.9 мянган тонн буюу 29.8 хувиар өссөн бол 2012 оноос 12.0 мянган тонн буюу 17.6 хувиар буурсан байна. Бетон зуурмаг үйлдвэрлэл 2017 онд 102.5 мянган м³ болж, өмнөх оноос 26.9 мянган м³ буюу 35.5 хувиар, 2007 оноос 55.5 мянган м³ буюу 2.2 дахин өсөж, 2012 оноос 73.7 мянган м³ буюу 41.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 8. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр, жил бүрийн эцэст

Он	Хүрмэн блок, мян.ш	Цул бетон, мян.м ³	Төмөр бетон эдлэл, мян.м ³	Хөнгөн бетон, мян.м ³	Замын хавтан, хашлага, мян.м ²	Бетон дэр, мян.ш	Хөөсөнцөр хавтан, мян.м ³
2007	286.3	3.5	29.6	21.6	14.4	68.5	28.8
2008	553.6	2.8	65.4	36.2	6.4	34.5	34.0
2009	387.5	0.8	13.6	16.7	5.7	78.9	5.3
2010	521.3	1.7	18.2	18.4	12.6	68.2	25.7
2011	467.7	0.9	61.3	29.6	96.4	39.2	39.2
2012	873.3	1.8	79.9	43.7	9.4	151.1	74.8
2013	692.2	8.4	76.9	28.6	11.1	125.6	15.1
2014	950.1	13.7	53.7	24.8	55.5	101.9	11.3
2015	633.2	13.2	36.6	20	7.3	80.0	5.8
2016	317.5	11.2	22.2	0.1	3.3	78.6	5.3
2017	252.1	6.7	39.5	3.4	2.9	104.6	31.4

Эх үүсвэр: АҮ-1 мэдээ, ҮСХ

Барилгын зарим нэр төрлийн бүтээгдэхүүний 2017 оны үйлдвэрлэлийг гол нэр төрлөөр авч үзвэл, хүрмэн блок 252.1 мянган ширхэг, цул бетон 6.7 мян.м³, төмөр бетон эдлэл 39.5 мян.м³, хөнгөн бетон 3.4 мян.м³, замын хавтан, хашлага 2.9 мян.м², бетон дэр 104.6 мянган ширхэг, хөөсөнцөр хавтан 31.4 мян.м³ тус тус үйлдвэрлэжээ.

Хүснэгт 9. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ИМПОРТ, жил бүрийн эцэст

Он	Цемент, мян.тонн	Цонхны шил, мян.м ²	Ширмэн радиатор, тонн	Арматур, катанка, мян.кг
2007	415.4	1 853.5	541.1	24 771.2
2008	643.3	1 436.6	742.3	18 594.6
2009	307.0	963.2	397.3	1 044.3
2010	445.1	923.1	808.0	20 074.3
2011	785.9	824.9	1 096.5	134 173.2
2012	1 192.3	1 848.4	1 111.8	143 994.6
2013	1 525.6	2 735.1	936.8	246 001.7
2014	1 506.0	2 645.9	797.7	265 336.8
2015	884.3	1 920.6	451.7	172 212.5
2016	252.6	1 534.7	279.8	71 636.9
2017	91.0	1 443.2	312.6	88 705.8

ТАВДУГААР БҮЛЭГ
БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО,
СУРАЛЦАГЧИД, ДУНДАЖ ЦАЛИН

5. БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО, СУРАЛЦАГЧИД, ДУНДАЖ ЦАЛИН

ХҮСНЭГТ 10. БАРИЛГЫН САЛБАРЫН 15 БА ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ АЖИЛЛАГЧДЫН ТОО, мянган хүнээр, жил бүрийн эцэст

Он	Улсын дүн	Барилгын салбар	Барилгын салбарын ажиллагчдын нийт дүнд эзлэх хувь
2007	1 024.1	31.8	3.1
2008	1 041.7	32.7	3.1
2009	1 006.3	49.6	4.9
2010	1 033.7	48.8	4.7
2011	1 037.7	52.0	5.0
2012	1 056.4	59.2	5.6
2013	1 103.6	72.4	6.6
2014	1 110.7	81.1	7.3
2015	1 151.2	88.1	7.7
2016	1 147.8	71.4	6.2
2017	1 238.3	70.6	5.7

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа, ҮСХ

Улсын хэмжээнд 2017 онд 1 238.3 мянган ажиллагчид байгаагийн 70.6 мянга буюу 6.2 хувь нь барилгын салбарт ажиллаж байна.

Барилгын салбарт ажиллагчдын тоог сүүлийн 10 жилээр авч үзвэл, 10 жилийн өмнөх буюу 2007 оноос 38.8 мянган хүнээр буюу 2.1 дахин, 5 жилийн өмнөх буюу 2012 оноос 11.4 мянган хүнээр буюу 19.3 хувиар тус тус нэмэгдэж, харин өмнөх оноос 0.8 мянган хүнээр буюу 1.1 хувиар буурсан байна.

Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвөөс хийсэн судалгаагаар тус салбарын нийт суралцагчдын тоо 2017 он байдлаар 24 263, шинээр элсэгчдийн тоо 9 013, төгсөх ангийн суралцагчдын тоо 9 618 байна.

Салбарын нийт суралцагчид - 24 263

Инженер, техникийн ажилтан -	10 458	Мэргэжилтэй ажиллагчид -	13 805
------------------------------	--------	--------------------------	--------



Шинээр элсэгчид - 9 013

Инженер, техникийн ажилтан -	2 450	Мэргэжилтэй ажиллагчид -	6 563
------------------------------	-------	--------------------------	-------




Төгсөх ангийн суралцагчид - 9 618

Инженер, техникийн ажилтан -	3 765	Мэргэжилтэй ажиллагчид -	5 853
------------------------------	-------	--------------------------	-------




2017 оны барилгын салбарын нийт хөдөлмөрийн эрэлт 9 808 байна.



Эх үүсвэр: БХБЯ-ны харьяа Барилгын хөгжлийн төвийн хийсэн судалгаа

ЗУРАГ 22. БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөгөөр, жил бүрийн 4-р улирлын байдлаар



Барилгын салбарт ажиллагчдын дундаж цалин 2017 оны 4-р улирлын байдлаар дунджаар 852.3 мянган төгрөг байгаа бөгөөд үүнээс эмэгтэй ажилчдын дундаж цалин 822.2 мянган төгрөг байна. Барилгын салбарт ажиллагчдын дундаж цалинг 10 жилийн өмнөх буюу 2007 онтой харьцуулахад 684.6 мянган төгрөг буюу 5.1 дахин өссөн байна. 2012 онтой харьцуулахад 367.2 мянган төгрөг буюу 75.7 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 122.5 мянган төгрөг буюу 16.8 хувиар тус тус өссөн байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ОРОН СУУЦНЫ ҮНЭ, ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

ОРОН СУУЦНЫ ҮНЭ

2017



УЛААНБААТАР ХОТ

ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 м2 ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ, сая.төг	2.21
ХУУЧИН 2 ӨРӨӨ ОРОН СУУЦНЫ ДУНДАЖ ҮНЭ, сая.төг	71.5



ОРОН НУТАГ

ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 м2 ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ, сая.төг	1.2
ОРОН СУУЦНЫ БОРЛУУЛАЛТ, хувь	50.1

ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ТҮХАЙ

8%

УЛААНБААТАР ХОТ	82%	БАЙРШИЛ
ОРОН НУТАГ	18%	
ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ДНБ-Д ЭЗЛЭХ ДУНДАЖ ХЭМЖЭЭ		15.7%

ОРОН СУУЦНЫ БОРЛУУЛАЛТ, орон нутагт



ХАМГИЙН ӨНДӨР - АРХАНГАЙ, ӨВӨРХАНГАЙ ХЭНТИЙ	
ХАМГИЙН БАГА - ДОРНОГОВЬ, ХОВД ОРХОН	
БОРЛУУЛАГДСАН ОРОН СУУЦ	6 725


Эх үүсвэр: Барилгын хөгжлийн төв, Монголын Ипотекийн корпорацын 2017 оны жилийн тайлан

6. ОРОН СУУЦНЫ БОРЛУУЛАЛТ, ҮНИЙН ИНДЕКС, ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН ТУХАЙ

Төрөөс 2013 оны 6 дугаар сараас орон сууцны ипотекийн 8 хувийн зээлийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь сүүлийн жилүүдэд ашиглалтад оруулсан орон сууцны тоо болон барилгын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн юм.

Тухайлбал, ипотекийн 8 хувийн зээлийн арга хэмжээ хэрэгжүүлж эхэлсэн 2013 оны сүүлийн хагасаас 2017 он хүртэлх хугацаанд ашиглалтад оруулсан орон сууцны тоо эрс нэмэгдэж, харин 2016 оны сүүлээр зээлийн санхүүжилтийг төрөөс түр хугацаагаар зогсоосон нь барилгын салбарын хөрөнгө оруулалтад нөлөөлж, улмаар барилга угсралт, их засварын ажлын хэмжээ болон ашиглалтад оруулсан орон сууцны тоо буурахад нөлөөлсөн байна.


ЗУРАГ 12. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА, ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО, мянган хүн, жил бүрийн эцэст



2017 онд 18.7 мянган айл бүхий орон сууцны зориулалттай барилга ашиглалтад оруулсан нь 10 жилийн өмнөх буюу 2007 оноос 15.0 мянган айлаар, 5 жилийн өмнөх буюу 2012 оноос 7.3 мянган айлаар нэмэгдэж, харин өмнөх оноос 0.4 мянган айлаар буурсан байна. Мөн 2017 онд шинээр 3991 иргэн ипотекийн зээлд шинээр хамрагдсан байна.

Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийн хүрээнд 2013-2017 онд орон сууцны борлуулалт 2 дахин нэмэгдсэн байна. Хөтөлбөрийн эхний жилүүдэд орон сууцны үнэ өсөж, орон сууцны үнийн индекс 2014 онд 1.26-д хүрсэн бол 2016 оны хагас жилээс хойш 0.98-1.02 түвшинд тогтворжиж байна.

Ипотекийн зээл олголт 2012 - 2017 он



Эх сурвалж: Монголбанк

Хүн амын бүтэц




Эх сурвалж: ҮСХ, МИК


Дэлхийн 103 орны ДНБ-д эзлэх ипотекийн зээлийн дундаж хэмжээ 2015 онд 25.1 хувь байсан бол Монгол Улсын хувьд энэ үзүүлэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 15.7 хувьтай байна. ДНБ-д эзлэх ипотекийн зээлийн хэмжээ дэлхийн дунджаас бага байгаа нь цаашид орон сууцны зээлийн хэмжээ тэлэх боломжтойг харуулж байна¹.

¹ Монголын Ипотекийн Корпорацийн жилийн тайлан - 2017

ЗУРАГ 23. ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН ОРОН СУУЦНЫ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ, НИЙСЛЭЛИЙН ДҮҮРГЭЭР, ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР




Орон сууцны үнийн индекс



Эх сурвалж: Тэнхлэг зууч


Ипотекийн зээл олголт ба орон сууцны борлуулалт



Эх сурвалж: Тэнхлэг зууч, Монголбанк

Монголбанк, Тэнхлэгч зууч ХХК-тай хамтран гаргасан орон сууцны үнийн индексийн судалгааны үр дүнгээр, 2017 оны 12 дугаар сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 0.2 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 0.3 хувиар тус тус өссөн байна. Тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ орон сууцны үнэ өссөн нь орон сууцны үнийн индекс өсөхөд голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 24. УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2013.01=1.00)



ШИНЭ ОРОН СУУЦНЫ ҮНЭ

Шинэ орон сууцны 1 м² талбайн дундаж үнэ 2017 оны 12 дугаар сарын байдлаар 2 205.0 мянган төгрөг болж өмнөх сараас 0.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар тус тус өссөн байна.


ХҮСНЭГТ 11. ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 м² ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ, 2017 оны 12 дугаар сарын байдлаар

Орон сууцны дундаж үнэ	2 205.0 мянган төгрөг
Жилийн өсөлтийн хувь	7.6 %
Сарын өсөлтийн хувь	0.2 %
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар дүүрэг
Хамгийн бага үнэтэй	Сонгинохайрхан дүүрэг


Эх үүсвэр: <https://www.mongolbank.mn/documents/prnews/2017/201712hpi.pdf>

Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны 1 м² талбайн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгинохайрхан дүүрэгт хамгийн бага үнэтэй байна.

ЗУРАГ 25. ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 м² ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ, сая төгрөгөөр



ЗУРАГ 26. ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М² ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ, дүүргээр, сая.төг



ХУУЧИН ОРОН СУУЦНЫ ҮНЭ – 2 ӨРӨӨ БАЙР


Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ 2017 оны 12 дугаар сарын байдлаар 71 542.0 мянган төгрөг болж, өмнөх сараас 0.45 хувиар өссөн бол өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 12. ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, 2017 оны 12 дугаар сарын байдлаар


Орон сууцны дундаж үнэ	71 542.0 мянган төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-3.43 %
Сарын өсөлтийн хувь	0.45 %
Хамгийн өндөр үнэтэй	Чингэлтэй дүүрэг
Хамгийн бага үнэтэй	Сонгинохайрхан дүүрэг

Эх үүсвэр: <https://www.mongolbank.mn/documents/prnews/2017/201712hpi.pdf>

ЗУРАГ 27. ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, сая төгрөгөөр



ЗУРАГ 28. ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, дүүргээр, сая.төг




Эх үүсвэр: Тэнхлэг зууч ХХК-ийн сар бүрийн тооцоолол

Чингэлтэй дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгинохайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ОРОН НУТАГТ ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРСОН ОРОН СУУЦНЫ БОРЛУУЛАЛТ

Барилгын хөгжлийн төвийн мэдээгээр 21 аймгийн нийт 6725 айлын 188 орон сууцаас 4 345 айлын орон сууц буюу 50.1 хувь нь борлуулагдсан байна.


ЗУРАГ 29. ОРОН НУТАГТ ШИНЭЭР АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БОРЛУУЛАЛТ, 2017 оны 4-р улирлын байдлаар, аймгаар, хувиар



Хамгийн өндөр борлуулалттай – Архангай, Өвөрхангай, Хэнтий аймгууд

Хамгийн бага борлуулалттай – Дорноговь, Ховд, Орхон аймгууд байгаа бөгөөд Завхан, Баянхонгор аймгуудад орон сууц борлуулагдаагүй байна. Орон нутагт шинэ орон сууцны борлуулалт дунджаар 50.1 хувьтай байна.

ЗУРАГ 30. АЙМГУУДЫН ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 м² ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ, сая төгрөгөөр



2017 оны 4-р улирлын байдлаар хөдөө орон нутгийн шинэ орон сууцны 1 м² талбайн дундаж үнэ – 1 178.0 мянган төгрөг байгаа бөгөөд Хөвсгөл, Орхон аймгуудад хамгийн өндөр үнэтэй байгаа бол Говьсүмбэр, Дундговь аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад бага үнэтэй борлуулагдсан байна.

Орон нутагт 6 725 айлын 188 орон сууцны барилга борлуулагдсанаас 516 айл нь төрийн албан хаагчдын, 629 нь төрийн орон сууц, 24 нь хувийн аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилчдын орон сууц, 5 556 нь хувь хүн, хувийн компаниудын орон сууц эзэлж байна.

ХҮСНЭГТ 13. ОРОН НУТАГТ БОРЛУУЛАГДСАН ОРОН СУУЦ, өмчийн хэлбэрээр

№	Аймаг	Нийт айлын тоо	Борлуулагдсан орон сууцны тоо	Өмчийн хэлбэрээр		
				Төрийн албан хаагчдын орон сууц	Төрийн орон сууц	Хувийн компаниудын ажилчдын орон сууц
1	Архангай	195	40	40	-	-
2	Баян-Өлгий	449	80	80	-	-
3	Баянхонгор	245	-	-	-	-
4	Булган	90	30	30	-	-
5	Говь-Алтай	466	302	-	302	-
6	Говьсүмбэр	324	120	120	-	-
7	Дархан-Уул	211	-	-	-	-
8	Дорнод	412	-	-	-	-
9	Дорноговь	1006	-	-	-	-
10	Дундговь	213	16	16	-	-
11	Завхан	130	20	20	-	-
12	Орхон	929	315	-	315	-
13	Өвөрхангай	41	-	-	-	-
14	Өмнөговь	727	12	12	-	-
15	Сүхбаатар	147	77	65	12	-
16	Сэлэнгэ	98	24	-	-	24
17	Төв	228	30	30	-	-
18	Увс	230	24	24	-	-
19	Ховд	433	44	44	-	-
20	Хөвсгөл	103	35	35	-	-
21	Хэнтий	48	-	-	-	-
Нийт		6725	1169	516	629	24

Тайлбар: Хувь хүн, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын 5 556 айлын орон сууцыг оруулаагүй.


ХҮСНЭГТ 14. УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС, 2017 оны 4-р улирлын байдлаар, төвийн 6 дүүргээр

Ашиглалтад оруулсан хугацаа	2017 X-XII	2017 X-XII	2017 X-XII
	2010 X-XII	2016 X-XII	2017 VII-IX
		хувь	
Ерөнхий индекс	182.2	99.4	100.0
Хан-Уул	179.8	99.6	100.1
1970 оноос өмнө	184.3	99.3	99.9
1970-2001 он	189.6	99.4	100.0
2001 оноос хойш	166.8	100.0	100.3
Баянзүрх	179.7	99.5	99.9
1970 оноос өмнө	163.0	99.0	99.9
1970-2001 он	189.1	99.5	99.9
2001 оноос хойш	177.0	99.7	100.0
Баянгол	176.6	99.2	100.0
1970 оноос өмнө	167.2	99.5	99.9
1970-2001 он	172.5	99.2	100.0
2001 оноос хойш	189.6	99.5	100.0
Сүхбаатар	196.4	99.6	100.0
1970 оноос өмнө	179.6	99.7	99.9
1970-2001 он	203.7	99.6	100.0
2001 оноос хойш	194.0	99.6	100.0
Чингэлтэй	190.7	99.6	100.1
1970 оноос өмнө	189.3	99.4	99.9
1970-2001 он	193.8	99.3	99.9
2001 оноос хойш	188.2	100.4	100.7
Сонгинохайрхан	178.7	99.2	99.9
1970 оноос өмнө	187.7	99.3	99.9
1970-2001 он	177.7	99.1	99.9
2001 оноос хойш	182.9	99.7	100.0

Тайлбар: Үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниудын мэдээлэлд үндэслэн тооцов. Орон сууцны үнийн зарим мэдээлэл байхгүй тохиолдолд статистикийн орлуулга хийх аргыг ашигласан.

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт орон сууцны үнэ 2017 оны 4 дүгээр улиралд 2010 оны эцсээс 82.2 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурсан бол өмнөх улиралтай харьцуулахад өөрчлөлт ороогүй байна. Орон сууцны үнэ 2017 оны 4-р улиралд өмнөх оны мөн үеэс Баянгол болон Сонгинохайрхан дүүрэгт 0.8 хувь, Баянзүрх дүүрэгт 0.5 хувь, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт 0.4 хувиар тус тус буурсан байна.

ЗУРАГ 31. ОРОН СУУЦНЫ ҮНЭ, хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, нийслэлийн төвийн 6 дүүргээр



1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнэ 2017 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс нийслэлийн төвийн 6 дүүрэгт 0.3-1.0 хувь, 1970-2001 оны орон сууцных 0.4-0.9 хувиар буурч, 2001 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцных Хан-Уул дүүрэгт өөрчлөлтгүй, Чингэлтэй дүүрэгт 0.4 хувиар өсөж, бусад дүүрэгт 0.3-0.5 хувиар буурсан байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ
БАРИЛГЫН САЛБАРЫН ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙН
ЧИГ ХАНДЛАГА

7. БАРИЛГЫН САЛБАРЫН ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Барилгын салбар манай улсад төдийгүй дэлхий дахинд идэвхжиж, орчин үеийн хүмүүсийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, инженерийн нарийн ур хийцтэй шийдэл бүхий байгаль орчинд ээлтэй барилга, байгууламж ихээр барих хандлагатай болж байна. Барилгын материал болон түүний үндсэн түүхий эд нь байгаль орчинд ямар нэг сөрөг нөлөөгүй, хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй байх нь хамгийн чухалд тооцогдож байна.

Дэлхийн хөгжлийн 10 чиг хандлага, 2017 оны байдлаар

1. Барилгын дизайн, төр – хувийн хэвшлийн түншлэл, нэгдсэн томоохон төсөл зэрэг 3 төрлийн хандлага давамгайлж байна.
2. Ажиллах хүчний хомсдол үйлдвэрлэлийн салбарт хэвээр хадгалагдана.
3. Тодорхой бус байдал шинэ удирдлагуудын шийдвэр, үйл хөдлөлөөс хамаарна. Татвар, хөдөлмөр эрхлэлтийн бодлого, бизнесийн бусад хууль эрх зүйн орчин зэрэг өөрчлөлтүүд нь удирдлагаас ихээхэн хамаарч байна.
4. Офсайт/Модуляр барилга илүү хүчтэй байр суурь эзэлнэ.
5. Барилгын ХХК-иуд ирээдүйн дэд бүтцийн санхүүжилтийг нэмэгдүүлэх талаар өөдрөг төсөөлөлтэй байна.
6. Интернэтээр ажлын байр, тоног төхөөрөмжийг хайж олох ажил нэмэгдэнэ.
7. Барилгын материалын үнэ, цалин хөлсний зардлын өсөлтөөс шалтгаалан барилгын нийт зардлын хэмжээ өснө.
8. Хиймэл болон бодит технологи нэмэгдэнэ.
9. Барилгын салбарын тогтвортой байдал нь салбарын хөгжлийг илүү тодорхой харуулна.
10. Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдалд хийх хяналт, шалгалт эрчимжинэ.

2017 оны байдлаар Барилгын салбарт хийгдсэн томоохон төслүүд

№	Төслийн нэр	ААНБ-ын нэр
1	Нарны хороолол	Хурд групп
	Хүннү 2222 резиденс	
	Рapid харш хороолол	
2	Гэгээнтэн цогцолбор	Жигүүр гранд групп
	Романа резиденс	
	Парк вью резиденс	
	Лакшари Зайсан виллэйж	
	Зайсан виллэйж	
	Хунгийн хотхон	
	Шинэ зуун хороолол	
	Наран хотхон	
	Гранд оффис центр	
Гранд плаза цогцолбор		
3	Ривер гарден	Номин девелопмент групп
	Ривер гарден - 2	
	Өнөр хотхон	
	Өнөр Эрдэнэт	
4	Алтай хаус хотхон	Алтай констракшн ХХК
	Алтай бюлдинг	
	Твин тауэр	
	Нархан хотхон	
	Экспресс тауэр	
Элит хотхон		
5	Маршал таун хотхон	Эко констракшн ХХК
	Голден парк 1,2 хотхон	
6	Гермес тесунг төсөл	Дельта констракшн ХХК
	Ноёд төсөл	
	Кристал таун	
	Дипломат хотхон	
	Эмбасси оффис тауэр	
Сонгдо Монголия оффис		
7	Хийморь 13 хотхон	Макс өргөө ХХК
	Кроун центр	
	220к резиденс	
	Макс центр	
	Элеганс лакшари апартмент	
	Макс тауэр	
	Хийморь 11 хотхон	
Хийморь хотхон		
8	Вива сити хороолол	Эм Си Эс проперти ХХК
	Будда виста хотхон	
	Белла виста хотхон	
	Шангри-Ла центр	
	АСЕМ виллэйж хотхон	
	Цэций хороолол	
	Сэлбэ хотхон	
9	Энканто таун цогцолбор	Камдер ХХК
10	Орчлон - 2 дунд сургууль	Суруга Монгол ХХК
11	Интэрнэйшнл сүүл оф Улаанбаатар	
12	Ниссан төв, шоу рүүм	Моннис пропертис ХХК

	Моннис тауэр Моннис бюлдинг	
13	Блю скай тауэр	Чоно групп ХХК
	Стрингс клуб	
	Вайт хаус зочид буудал	
	Мишээл экспо	
14	Зайсан хилл	Оюуны Ундраа пропертиз ХХК
	Зайсан скүэр	
	Зайсан резиденс	
14	Содон хороолол	Тэсо констракшн ХХК
15	Юу Би централ резиденс	Гангар инвест ХХК
	Ногоон төгөл хотхон	
16	Хийморь цогцолбор хотхон	Заг ХХК
	Парк хаус	
	Оюу толгой оюутны дотуур байр	
	Ногоон нуга хотхон	
17	Соло молл худалдааны төв	Орчлон констракшн ХХК
	Шинэчлэл 3 орон сууц	
18	Туул кондоминиум хотхон	Пума констракшн ХХК
19	Баянмонгол хороолол	Их үйлсийн эрэлд ХХК
	Их монгол хороолол	
	Их монгол резиденс	
	Их монгол цогцолбор	
	Их монгол оффис	
20	Эрин хороолол	Эрин интернэшнл ХХК

ДҮГНЭЛТ

Монгол Улсын барилгын салбарт 2017 онд нийт 12.1 мянган ААНБ үйл ажиллагаа явуулж 70.6 мянган хүн ажиллаж, 962.3 тэрбум төгрөгийн нэмэгдэл өртгийг бий болгосон байна. Хүн амын нутагшилт, суурьшлын хот, тосгоны төлөвлөлтийг боловсронгуй болгож, хүн амын тав тухтай аж төрөх нөхцөлийг бүрдүүлэх, улс орны тогтвортой хөгжлийг хангахад хот байгуулалтын талаар төрөөс баримтлах тогтвортой, оновчтой бодлого маш чухал үүрэгтэй. Сүүлийн жилүүдэд төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөр нь эдийн засагт үр нөлөөгөө шууд болон шууд бусаар өгч байгаа нь уг танилцуулгад дурдагдсан тоон мэдээллээс тодорхой харагдаж байна. Цаашид салбарын тасралтгүй өсөлтийг хангах, тооцоо, судалгаатай төрийн тогтвортой бодлогыг оновчтой үргэлжлүүлэх, шинэлэг төсөл, хөтөлбөрийг боловсруулж үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Барилгын салбарын ажиллагчдын тоо, дундаж цалин жилээс жилд нэмэгдэж байгаагаас гадна барилга угсралт, их засварын ажлын хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй өссөөр байна. Улсын хэмжээнд сургууль, цэцэрлэгийн болон замын барилга угсралтын ажил сүүлийн 5 жилийн хугацаанд өмнөх 5 ажилтай харьцуулахад эрчимтэй нэмэгдсэн байна. Сүүлийн жилүүдэд төрөөс хэрэгжүүлсэн Ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй орон сууцны зээл нь иргэдэд үр өгөөжөө өгч, зээл олгож эхэлснээс хойш 93.4 мянган иргэн хамрагдаж, өөрийн эзэмшлийн орон сууцтай болсон байна. Барилга угсралтын ажил эрчимтэй өрнөж байгаагийн дийлэнх хувь нь нийслэл Улаанбаатар хотод явагдаж байгаа бөгөөд үүнийг даган энгийн орон сууцаас гадна чинээлэг хэрэглэгчдэд зориулсан, тэдний хэрэгцээ шаардлагыг хангах 1 м² талбайн дундаж өртөг 2.5 саяас дээш тансаг зэрэглэлийн орон сууцууд олноор баригдаж байна. Мөн орон сууцны бус барилга, ялангуяа худалдаа, үйлчилгээний барилга угсралтын ажил эрчимтэй нэмэгдэж байгаа нь барилга угсралтын ажлын бүтцээс тодорхой харагдаж байна. Орон сууцны үнэд сүүлийн 10 жилийн хугацаанд огцом өөрчлөлт гарсан нь төрөөс авч хэрэгжүүлсэн бодлого, шийдвэрүүдээс шууд хамааралтай байна.